# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2018 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
## “НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

### *1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт*:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгасан 209 арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн харилцааны газарт хамаарах 3 ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тооцон ажиллаж байна.

*5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.* *Хэрэгжилт 90%*

- ✓ Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх
- ✓ Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох

### *1.2 Нийслэлийн Засаг даргын /НЗД/ үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт*:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1 зорилтын хүрээнд Өмчийн харилцааны газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу Эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 4 ажлын хэрэгжилтийг ханган ажиллахаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. *Хэрэгжилт 100%*

### *1.6.1 Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт,үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ.*

*Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж /хяналтыг сайжруулан/ тэвчиж болох худалдан авалт, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх.* *Хэрэгжилт 90%*

Нийслэлд 2017 онд 33 нийслэлийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулснаас 2018 оны 01 дүгээр сард нээлттэй дуудлага худалдаагаар Усан спорт сургалтын төв

ОНӨААТҮГ-ыг хувьчлагдан 2018 онд 21 аж ахуйн тооцоот, 11 төсөвт нийт 32 нийслэлийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон, худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэвчиж болох худалдан авалт, удирдлагын үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх бодлогыг баримтлан 32 үйлдвэрийн газрын эдийн засгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж 2018 оны зорилтын төслийг хянан орлогыг 866.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлыг 4,181.2 сая, алдагдлыг 5,047.9 сая төгрөгөөр тус тус бууруулах, худалдан авалтыг 21.2 тэрбум төгрөг байхаар санал боловсруулан НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн НЗД-ын 2018.03.28-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар батлуулсан.

Захирамжаар нийслэлийн өмчит 32 үйлдвэрийн газрын 2018 оны нийт орлого 244.9 тэрбум, зардал 273.6 тэрбум, алдагдал 28,6 тэрбум төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,12 төгрөгөөр баталсан. Энэ нь 2017 оны гүйцэтгэлээс орлого 3.5 тэрбум, зардал 2.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэн, алдагдал 720.4 сая төгрөгөөр буурсан. Эхний хагас жилийн байдлаар орлого 131.6 тэрбум, зардал 140.9 тэрбум, алдагдал 9,4 тэрбум төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,07 төгрөгт хүрч зорилтыг хангаж ажиллаж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс /ЭБХХХК/-ын 20 удаагийн хурлаар 14 байгууллагын 4,504,321.4 мянган төгрөгийн хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагын балансад, 24 байгууллагын 652,091.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд тус тус шилжүүлэх, 40 байгууллагын 504,827.3 мянган төгрөгийн хөрөнгийг шинээр худалдан авах асуудлыг шийдвэрлэж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Төсвийн зардлыг хэмнэх, тэвчиж болох худалдан авалтыг бууруулах бодлого баримтлан ажиллаж худалдан авалтыг 2017 оноос ***641,460,438*** төгрөгөөр бууруулсан.

Техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон, акталж данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулж нийслэлийн төсөвт ***150,750,200*** төгрөг төвлөрүүлэн биелэлт 193%-тай байна.

*1.2.2 Улаанбаатар хотын дүүрэг бүрд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг барьж "Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.*

*Дүүргийн ОНӨҮГ-үүдын эрх зүйн орчинг боловсронгуй болгож үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлж эхлэнэ.* *Хэрэгжилт 70%*

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг нэгдсэн бодлогоор хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, хяналт тавих зорилгоор 48 үйлдвэрийн газрын судалгаа гарган 2017 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланг хүлээн авч Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулан өмчийн ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Судалгаагаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд гудамж зам талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн тохижилт, хог тээврийн үйлчилгээ явуулдаг 14 үйлдвэрийн газрын үйл ажиллагаа нь давхардсан байна. Тус газруудын үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулах, хяналт тавих, нэгдсэн бодлогоор хангах, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар санал ирүүлэх тухай хүсэлтийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2/1485 тоот, Хот тохижилтын газарт 2/1495 тоот албан бичгээр тус тус хүргэсэн. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 9 дүүргийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг удирдлагын нэгдсэн бодлогоор хангах, менежментийг сайжруулах, үйлдвэрлэл эрхлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхэд хэрхэн уялдаа холбоотой

ажиллах талаар санал ирүүлэх тухай хүсэлтийг Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд 2/1478 тоот албан бичиг хүргэсэн.

*Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.*

*Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх, нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ:* *Хэрэгжилт 90%*

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас /ТӨБЗГ/ 2018.01.18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл, 2017 оны улсын нэгтгэлд анхаарах асуудлууд”, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн танилцуулга” сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмжийг 9 дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2018 оны 3/180, 3/217-3/224 тоот албан бичгүүдийг хүргэсэн.

ТӨБЗГ–ын “Дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 273 дугаар тогтоолын үүрэг даалгаврыг 2018.06.28-ны өдрийн 3/1061 тоот албан бичгээр нийслэлийн өмчит 758 байгууллагын удирдлагад хүргэсэн. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэх,
2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан хөрөнгийн ангиллын кодыг хөтөлж хэвшүүлэх,
3. “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д мэдээллээ оруулах,

Сангийн сайдын 2018.08.07-ны өдрийн 207 дугаар тушаалаар үнэлгээ хийх аргачлал, ТӨБЗГ-ын 2018.08.14-ний өдрийн 367 дугаар тогтоолоор үнэлгээний ажлыг зохион байгуулах зааврыг тус тус баталж аргачлал, зааврын дагуу дахин үнэлгээний ажлыг орон нутагт зохион байгуулан нэгдсэн тайланг 2019.03.15-ны өдрийн дотор ирүүлэхийг манай байгууллага болон аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус даалгасан байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын болон аймгуудын өмчийн газрын холбогдох албан тушаалтнуудыг хамарсан төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээний ажлын сургалтыг ТӨБЗГ-аас 2018.09.06-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийслэл, дүүргийн өмчит хуулийн этгээдүүдэд зориулсан дахин үнэлгээний сургалтыг ТӨБЗГ-тай хамтран 2018.09.27-28-ны өдрүүдэд зохион байгуулж үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг эхлүүлсэн.

*4.1.9 "Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ.*

*Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.* *Хэрэгжилт 70%*

1. Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч НЗД-ын орлогч Ш.Анхмаагийн 2018.03.05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу нийслэлийн өмчит ерөнхий

боловсролын сургуулиудын 2017-2018 оны хичээлийн жилийн “Үдийн цай” хөтөлбөр, цайны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг нийслэлийн өмчит сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Хамтран ажилласан байгууллага:

- Дүүргийн мэргэжлийн хяналтын газар
- Дүүргийн Боловсролын газар
- Дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
- Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг

Шалгалтыг 2018.03.05-16-ны өдрүүдэд нийт 114 сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг 108 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлдөггүй
- Байр ашиглалтыг сайжруулдаггүй
- Хориглосон бүтээгдэхүүн худалдаалдаг

*4.2.13. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын шаардлага хангахгүй барилгыг шинэчлэх, шинээр барих бэлтгэл ажлыг эхлүүлнэ.*

*<u>Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийг зориулалтын байртай болгоно.</u>*

НЗД-ын 2018 оны А/132 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвд зориулж шаардлага хангасан барилга худалдан авах ажлыг зохион байгуулах шийдвэрлэн худалдан авах ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосны дагуу газрын даргын 2018 оны А/104 дүгээр тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулсан.

Барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2018.04.23-ны өдөр зарлан, урилгыг tender.gov.mn болон Өдрийн сонинд нийтэлж тендерийн материалыг 2018.05.24-ний өдөр хүлээн авч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулсан. "Алтан горхи" ХХК-тай 4,626,500,760.0 төгрөгийн гэрээ байгуулах Үнэлгээний хорооны зөвлөмжийг 2018.07.04-ний өдрийн 1/1102 тоот албан бичгээр НЭМГ-т хүргүүлсэн. Барилга ашиглалтад оруулах Улсын комисс 2018.09.13-ны өдөр Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвд зориулж шаардлага хангасан барилгыг хүлээн авч ашиглагч байгууллагад комиссын актаар хүлээлгэж өгсөн.

*Улаанбаатар хотын “Аз жаргалтай хот индекс”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллана.*

1. *<u>“Аз жаргалтай хот индекс” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсвийн зардлыг хэмнэх бодлого хэрэгжүүлэн ажиллана.</u>*

2. *<u>Нийслэлийн өмчит сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдийн техник хэрэгсэл, эд хөрөнгө худалдан авах хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинээр бэлтгэн нийлүүлэх эд хөрөнгийг судалж, эд хөрөнгийн илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад балансаас балансад шилжүүлэх замаар өмчийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх</u>*

"Аз жаргалтай хот индекс" шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийслэлийн өмчит сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдийн техник хэрэгсэл, эд хөрөнгө худалдан авах хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинээр бэлтгэн нийлүүлэх эд хөрөнгийг судалж нийт 6 байгууллагын 22 нэр төрлийн 88,911,734 төгрөгийн эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар ЭБХХХК-ын 6 удаагийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвөөс тус дүүргийн нийт 32 өрхийн эрүүл мэндийн төвд 55,564,128.9 /тавин таван сая таван зуун жаран дөрвөн мянга нэг зуун хорин найман сая/ төгрөгийн тоног төхөөрөмж;
- Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2,332,943.6 төгрөгийн тоног төхөөрөмж;
- Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэгээс тус дүүргийн 189 дүгээр цэцэрлэгт 1,220,920 төгрөгийн тавилга эд хогшил;
- Чингэлтэй дүүргийн 43-р цэцэрлэгээс тус дүүргийн 19-р цэцэрлэгт 4,380,000.0 төгрөгийн тавилга эд, хогшил, тоног төхөөрөмж
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвөөс тус дүүргийн 4 өрхийн эрүүл мэндийн төвд 4,733,660.0 төгрөгийн тоног төхөөрөмж
- Баянзүрх дүүргийн 168 дугаар цэцэрлэгээс тус дүүргийн 203 дугаар цэцэрлэгт 20,680,080.0 төгрөгийн эд хогшил

*Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлүүлнэ.*

НЗДТГ-аас зохион байгуулсан "Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, сайжруулах аргачлал"-ын сургалтад заасны дагуу газрын даргын үр дүнгийн гэрээний 1.8, 1.9 тусгасан үндсэн чиг үүргийн дараах ажлуудын гүйцэтгэлийг сар, улирлаар гаргаж байна.

➢ 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар:

- нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлого 654,914.2 мянган төгрөг /81.86%/,
- нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудаас нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг 0 төгрөг,
- улс, нийслэлийн хөрөнгө оруулалт, бусад төрлийн эх үүсвэрээр бий болсон барилга байгууламж, тээврийн хэрэгслийг захиалагч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 12,069,700.0 төгрөгийн хөрөнгө нийслэлийн өмчид бүртгүүлсэн,
- нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 2,979,811.0 мянган төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн,
- ЭБХХХК-ын хурлаар оруулан 172,080.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгосон,
- нийслэлийн өмчийн төсөвт 660 байгууллагуудын "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2017 оны биелэлтийг дүгнэн дундаж 80 оноо байна.

➢ 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар

- нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын гүйцэтгэл 98% буюу 1,176,369.3 мянга, өмч хувьчлалын орлого 8.7 тэрбум, ногдол ашгийн орлого 290,454.5 мянга, актлагдсан хөрөнгийн орлого 15,977.2 мянган төгрөг нийт 10,223.4 сая төгрөг төвлөрүүлсэн,
- батлагдсан зорилтот түвшингээс НӨҮГ-ын орлого 9,114,113.9 мянган төгрөг /7%/-р давж, зардал 4,186,738.7 мянган төгрөг /3%/ хэмнэн 9,389,884.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан,

- улс, нийслэлийн хөрөнгө оруулалт, бусад төрлийн эх үүсвэрээр бий болсон барилга байгууламж, тээврийн хэрэгслийг захиалагч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 24,914,291.4 мянган төгрөгийн хөрөнгө нийслэлийн өмчид бүртгүүлсэн,
- нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 101,968.973.0 мянган төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн,
- ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр 3,329,342.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэх, 504,827.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгосон
- Нийслэлийн өмчит төсөвт 660 байгууллагын удирдлагатай байгуулсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэн дундаж оноо 80 болсон ба өмнөх оноос 2 пунктээр дээшилсэн байна.









Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэсэн харьцуулалт




## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## “ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийслэлийн санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлийн дагуу төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үе

шаттай зохион байгуулаж бусад ажлуудыг дараах төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган хяналт тавин ажиллаж байна.

*1. Байгууллагын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө*

*2. НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

*3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

*4. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2018 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө*

*5. 2018 онд зохион байгуулагдах “Сургалтын төлөвлөгөө”,*
*Мэдээллийн цагийн хуваарь*

*6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө*

*7. Монгол Улсын Засгийн газрын "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.10.26/*

*8. 2018 онд “Спорт хамтлаг”-ийн зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө*

*9.Авилгын эсрэг 2018 оны төлөвлөгөө*

*10.2018 оны архивын ажлын төлөвлөгөө*

### *2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:*




- Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах 2 ажлын саналыг 2018.02.14-ний өдрийн 1/279 тоот албан бичгээр, НЗД-ын Зөвлөлийн хурлаар 2018 онд хэлэлцүүлэх 4 асуудлын саналыг 2018.01.16-ны өдрийн 1/62 тоот албан бичгээр тус тус НЗДТГ-т хүргэсэн.

- Байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой төсвийн орлого бүрдүүлэлт, нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын зорилтот түвшин, нийслэлийн хөрөнгийн бүртгэл, худалдан авалт, өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлттэй холбоотой 5 ажлыг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр /KPI/ сонгон 2015-2017 оны үр дүнг тооцон гаргаж 2018.01.24-ний өдрийн 1/104 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргэсэн.

- Байгууллагын “Дунд хугацааны стратеги төлөвлөгөө” шинэчлэн боловсруулж газрын даргын 2018.06.14-ний өдрийн Б/269 дугаар тушаалаар батлуулсан.

- НЗД-ын 2017.11.30-ны өдрийн А/918 дугаар захирамжаар төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, нийслэлээс хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгч, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах, хорооны үйл ажиллагааг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилтын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын хариуцан ажиллах хороодын хуваарь болон удирдамжийг баталсан. Байгууллагын 7 удирдах албан тушаалтан Баянгол дүүргийн 14, 15, 17, 18, 19, 20, 21, Хан-Уул

дүүргийн 7 дугаар хороодын Засаг дарга нарт уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан 2018.02.14-ний өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэндчилгээг уламжлан, хороодод хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд, цаашид анхааран хийж хэрэгжүүлэх ажлуудын талаар ярилцан санал солилцож, холбогдох албан тушаалтан, байгууллагуудад уламжлан ажиллаж байна. Хороодод ажилласан талаарх сар бүрийн мэдээ тайланг цаг хугацаанд НЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлж байна. Хариуцсан хорооны нийт өрх, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, түлш борлуулдаг цэг, нүүрс борлуулдаг зах, өрхийн судалгаар Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газарт 2018.05.11-ний 1/824 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2018 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, 2018.01.25-ны өдөр газрын даргаар батлуулж, хагас жилийн биелэлтийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэст 2018.07.09-ний өдрийн 1/1162 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Төрийн бүх шатны байгууллагад сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газраас 2018.08.22-ны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, НЗД-ын 2018.08.30-ны А/798 дугаар захирамжийн дагуу газрын даргын 2018.09.03-ны өдрийн А/466 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийн, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар дүн шинжилгээ хийж тайланг НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2018.09.18-ны 1/1435 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурал 7, Ёс зүйн хороо 3 удаа хуралдан хуралдааны тэмдэглэлийг хөтөлж шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Нийслэл дэх төрийн Аудитын газрын бүтцийн аудитад 17, Авлигатай тэмцэх газрын шалгалтад 12 төрлийн судалгаа гарган хүргэсэн.

Шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийн талаар:

| Зөвлөгөөний төрөл | Хурлын тоо | Үүрэг даагавар | Биелэлт |
|---|---|---|---|
| Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн | 17 удаа | 38 | 100% |
| Байгууллагын шуурхай зөвлөгөөн | 22 удаа | 229 | 208 – 100%<br>21– хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |

Газрын даргын Шуурхай зөвлөгөөний хурлыг 7-14 хоногийн хугацаанд тогтмол зохион байгуулан тайлант хугацаанд 22 удаагийн хурлаар хэлтсүүдэд 239 үүрэг даалгавар өгсөн байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### *3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:*

Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагчтай Үр дүнгийн гэрээг 2018.02.05-ны өдөр байгуулан нийт 47 ажил үйлчилгээ, 11 тусгай захиалгат ажлыг байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



*3.1.Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулна.*

НЗД-ын 2018 оны А/45 дугаар захирамжаар орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан 5 удаагийн хурлаар 32 үйлдвэрийн газрын 2018 оны орлого, зардал, ашиг, алдагдал, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг хэлэлцүүлсэн.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтыг хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын мөрийн хөтөлбөрт үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэхээр тусгасан заалтуудыг үндэслэн үйл ажиллагааны үр дүнг 2017 оны түвшингээс бууруулахгүй, үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэхийг дэмжих, үндсэн үйл ажиллагаанаас гадна, бусад төрлийн орлого гол нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах боломжит арга замыг хэрэгжүүлэх зэрэг бодлого баримтлан ажиллалаа.

Үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг хянан, орлогыг 866.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, зардлыг 4,181.2 сая, алдагдлыг 5,047.9 сая төгрөгөөр тус тус бууруулах санал боловсруулан, НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НЗД-ын 2018 оны А/259 дүгээр “Зорилт батлах тухай” захирамжаар баталсан.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын
2018 оны зорилтот түвшин

*/тэрбум төгрөг/*




Нийслэлийн өмчит 32 үйлдвэрийн газар нь 2018 онд 244,9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 273,6 тэрбум төгрөгийн зардал, 28,6 тэрбум төгрөгийн алдагдал гарган, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,11 төгрөг болгох зорилттой ажиллаж байна. Энэ 2017 оны гүйцэтгэлээс орлого 3,5 тэрбум, зардал 2,8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, алдагдлыг 720,4 сая төгрөгөөр бууруулж ажиллахаар байна.

Зорилтоор 28.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн нь дараах үйлдвэрийн газруудын алдагдал эзэлж байна. Үүнд:

- Холбогдох зохицуулах хороодын үнэ тарифын дагуу нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Ус сувгийн удирдах газар 18.0 тэрбум, Зорчигч тээврийн нэгтгэл 5.3 тэрбум төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 4.5 тэрбум, Хэсэгчилсэн инженерийн удирдах газар 507.8 сая төгрөг,
- Нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэлтэй байдгаас элэгдлийн зардлаар Геодези, усны барилга байгууламжийн газар 1,607.2 сая төгрөг,
- Зорчигч тээврийн нэгтгэл 5.4 тэрбум төгрөг, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 507.8 сая төгрөг, Нийслэлийн Төр захиргааны авто бааз 218.0 сая төгрөг, Үртсэн шахмал түлшний үйлдвэр 115.1 сая төгрөгийн алдагдал тус тус хүлээж байна.
-



НЗД-ын 2018 оны А/356 дугаар захирамжаар орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контрактын биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан 7 удаагийн хурлаар нийслэлийн өмчит 32 үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлтийг хэлэлцэн дүн, танилцуулгыг НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, НЗД-ын 2018

оны А/597 дугаар захирамжаар баталгаажуулсан.

Үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контрактыг дүгнэж дараах үнэлгээг өгсөн. Үүнд:

- Бүрэн хангалттай - 8 үйлдвэрийн газар
- Хангалттай - 20 үйлдвэрийн газар
- Ажил сайжруулах - 4 үйлдвэрийн газар

Дээрх захирамжийн дагуу 19 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай Контракт, 13 төсөвт үйлдвэрийн газрын захиралтай Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулан биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

### *3.1.2. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, дүрмэнд өөрчлөлт оруулах талаар:*

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”, “Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ыг өөрчлөн хувьцаат компани болгох, хувьцааны тоог тогтоох уулзалт зохион байгуулж эзэмшиж буй газрын үнэлгээг оруулан тооцох, хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай 2018 оны 2/751 тоот, компанийн дүрэмд оруулах саналын тухай 2/576 тоот албан бичиг тус тус хүргэсэн. НИТХТ-ын 2 удаагийн хурлаар “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ыг хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах тогтоолын төсөл, дүрмийг хэлэлцүүлэн НИТХТ-ийн 2018.04.20-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Нийслэлийн орон сууцны корпораци” хаалттай ХК болгон өөрчлөн байгуулсан.

Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөтгөн “Олон улсын худалдаа, логистикийн төв” ХК болгох асуудлаар тус байгууллагын дүрмийн төсөлтэй танилцан НИТХТ-ын 2 удаагийн хурлаар хэлэлцүүлж, 2018.03.23-ны өдрийн 28 дугаар тогтоолоор өөрчлөн байгуулан, дүрмийг батлуулсан.

НЗД-ын 2018.03.26-ны өдрийн А/239 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ыг 2 үйлдвэрийн газар болгох санал боловсруулан НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж 2018.05.23-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ыг байгуулахаар шийдвэрлсэн. НЗД-ын 2018 оны А/540 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн саналын дагуу НЗД-ын 2018 оны А/723 дугаар захирамжаар нийт 18,286,9 сая төгрөгийн хөрөнгийг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Газрын даргын 2018 оны А/461 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хөрөнгийг актаар хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн төсвийн ачааллыг бууруулах үүднээс “Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгаж, Нийслэлийн Байгаль орчны газарт нэгтгэх асуудлыг судлан танилцуулга, тогтоолын төсөл боловсруулан НЗД-ын 2018 оны 01/3598 тоот албан бичгээр НИТХТ-ийн хуралд өргөн бариад байна.

### *3.1.3. НӨҮГ болон оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх талаар:*

НИТХТ-ын 2016 оны 61 дүгээр тогтоолоор томилогдсон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын Удирдах зөвлөл, НИТХТ-ийн 2016 оны 03 дугаар тогтоолоор томилогдсон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд өөрчлөлт оруулах асуудлыг НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны 102 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 7 хуулийн этгээдийн ТУЗ, УЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.

“Олон улсын худалдаа, логистикийн төв” хаалттай ХК-ны ТУЗ гишүүдийг томилох тухай асуудлыг хэлэлцүүлэн, НИТХТ-ийн 2018 оны 102 дугаар тогтоолоор, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын УЗ гишүүдийг томилуулах тухай асуудлыг хэлэлцүүлэн, НИТХТ-ийн 2018 оны 133 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлүүлсэн.

НӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах санал хүргүүлж холбогдох албан хаагчид оролцож саналаа тусгуулж ажиллаа. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар - 1
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар - 2
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар - 3
- Хот тохижилтын газар - 2
- Зураг төслийн хүрээлэн - 1
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар - 1
- Гэрлэх ёслолын ордон - 1
- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар -1
- Зорчигч тээвэр гурав -1

“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2018.06.08-ны өдрийн хуралд хэлэлцүүлэх асуудлыг боловсруулан удирдамжийг батлуулж итгэмжлэгчийг томилон оролцуулсан.

### *3.1.4. Төсөвт газруудтай байгуулсан Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх ажлын талаар:*

Газрын даргын 2018.03.27-ны өдрийн А/82 дугаар тушаалаар орлогч дарга Д.Мөнхсайханаар ахлуулсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, ажлын удирдамж, дүгнэх үзүүлэлтүүд, шаардлагатай зардлын төсвийг батлсан. Удирдамжийн дагуу гэрээний биелэлтийг 2018.04.02-05.01-ний өдрийн хороонд дүгнэж нэгдсэн дүнг Илтгэх хуудсаар танилцуулсан.

Өмчийг эзэмшүүлэх гэрээний гэрээний биелэлт дүгнэх ажлыг Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолоор үүрэг болгосон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын бэлтгэлийг хангахад чиглүүлэн зохион байгуулсан.

*Дүгнэх үзүүлэлтүүд, хамрагдсан нийслэлийн өмчит төсөвт байгууллагын талаар:*

Нийслэлийн Өмчийн харилцааны газар болон холбогдох бусад байгууллагаас өмч хөрөнгөтэй холбоотой гаргасан тушаал, шийдвэрийн биелэлтийг шалгах, хөрөнгийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалт, эзэмшил газрын баталгаажилт, кадастрын зураглал, барилга байгууламжийн хувийн хэргийн хөтлөлт зэрэг 3 багц бүхий 11 үзүүлэлтээр, тодруулбал түрээсийн гэрээтэй байгууллагуудыг 11 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор, түрээсгүй байгууллагуудыг 9 үзүүлэлтээр 85 хүртэлх оноогоор дүгнэв.

Төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээний 2017 оны биелэлтийг дүгнэх ажилд 660 байгууллага хамрагдахаас 97,7% хувь буюу 645 байгууллага хамрагдлаа. Байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр ангилбал:

| Байгууллага/ дүүрэг | БНД | БХД | БГД | БЗД | НД | СХД | СБД | ХУД | ЧД | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэг | 9 | 2 | 33 | 41 | 7 | 45 | 32 | 29 | 29 | 227 |
| Сургууль | 3 | 1 | 17 | 25 | 5 | 19 | 16 | 18 | 15 | 119 |
| Өрхийн эмнэлэг | 4 | | 22 | 27 | 4 | 27 | 18 | 15 | 16 | 133 |
| Эрүүл мэндийн байгууллага | 2 | 1 | 3 | 5 | 1 | 3 | 5 | 3 | 1 | 24 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төсөвт байгууллага албан газар | 9 | 11 | 12 | 17 | 14 | 15 | 17 | 15 | 13 | 123 |
| Нийслэлийн төр захиргааны байгууллага | | | 1 | | | | 11 | 1 | 21 | 34 |
| Нийт | 27 | 15 | 88 | 115 | 31 | 109 | 99 | 81 | 95 | 660 |

| Үнэлгээ | БНД | БХД | БГД | БЗД | НД | СХД | СБД | ХУД | ЧД | Нийслэлийн төр захирганы байгууллагууд | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүрэн хангалттай | 17 | 14 | 80 | 72 | 28 | 61 | 77 | 67 | 63 | 27 | 506 |
| Хангалттай | 6 | 1 | 6 | 33 | 3 | 43 | 6 | 9 | 8 | 2 | 117 |
| Ажил сайжруулах | 2 | | | 6 | | 3 | 4 | 3 | | 1 | 19 |
| Хангалтгүй | | | 1 | | | 1 | 1 | | | 0 | 3 |
| Дүгнэгдээгүй | 2 | | | 4 | | 1 | | 1 | 3 | 4 | 15 |
| Нийт | 27 | 15 | 87 | 115 | 31 | 109 | 88 | 80 | 74 | 34 | 660 |




“Тэргүүний өмч эзэмшигч” байгууллагаар 9 дүүрэг тус бүрд дараах байгууллагуудыг шалгаруулав. Үүнд:

1. Багануур дүүрэг – Боловсрол цогцолбор сургууль
2. Багахангай дүүрэг – Хангай цогцолбор сургууль
3. Баянгол дүүрэг – 73 дугаар сургууль
4. Баянзүрх дүүрэг – 210 дугаар цэцэрлэг
5. Налайх дүүрэг - 23 дугаар цэцэрлэг
6. Сонгинохайрхан дүүрэг – 104 дүгээр сургууль
7. Сүхбаатар дүүрэг - Ажилчин залуучуудын ээлжийн сургууль
8. Хан-Уул дүүрэг – Засаг даргын Тамгын газар
9. Чингэлтэй дүүрэг – 56 дугаар цэцэрлэг

Гэрээний биелэлтийн дүнгээр “Ажил сайжруулах”, “Хангалтгүй” үнэлгээ авсан нийслэлийн өмчит дор дурдсан төсөвт байгууллагуудын удирдлагад гэрээг цуцлах талаар сануулах арга хэмжээ авах саналыг Нийслэлийн Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

“Ажил сайжруулах” үнэлгээ авсан:

- Багануур дүүргийн ЗДТГ, Зоонозын өвчин судлалын төв

- Баянзүрх дүүргийн 53 дугаар сургууль, Хонхорын Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн 2, 3 дугаар хэлтэс,
- Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир спортын хороо, Цагдаагийн 2, 3 дугаар хэлтэс
- Сүхбаатар дүүргийн 71 дүгээр сургууль, 8 дугаар хорооны Манай эмч ӨЭМТ, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс
- Хан-Уул дүүргийн 243 дугаар цэцэрлэг, Соёлын ордон, Цагдаагийн 2 дугаар хэлтэс
- Нийслэлийн Мал эмнэлгийн газар

“Хангалтгүй” үнэлгээ авсан:

- Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс
- Сонгинохайрхан дүүргийн Хүүхдийн клиник сувилал 41
- Сүхбаатар дүүргийн ИТХ

### *3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил*

#### *3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар:*

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, тайлант онд хийгдсэн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг өмчийн мэдээллийн санд бүрэн гүйцэд оруулсан эсэхийг шалгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын болон дотоодын хандив, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр шинээр бий болсон нийт **39,982,809,912** төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна. Үүнд:

1. Барилга байгууламж 23 — **20,647,723,711** төгрөг
2. Авто зам 1 — **598,807,720** төгрөг
3. Тээврийн хэрэгсэл 34 — **3,667,750,000** төгрөг
4. Нийтийн эзэмшлийн хөрөнгө, их засварын ажил — **3,146,245,926** төгрөг
5. ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө – **3,329,342,555** төгрөг
6. Шинээр бий болсон эд хөрөнгө – **8,592,940,000** төгрөг

*1. Барилга байгууламж*

| *НИТХТ-ийн 2017 оны 170 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/47 дугаар захирамж* | | |
|---|---|---|
| № | Барилга байгууламжийн нэр | Бүртгэлийн үнэ /төгрөг/ |
| 1 | БЗД-ийн 23-р хороо, Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга, байгууламж | 2,641,136,809 |
| 2 | БЗД-ийн 16 дугаар хороо, 21 дүгээр цэцэрлэгийн барилга | 2,364,810,219 |
| 3 | БЗД-ийн 4 дүгээр хороо, Сайханы хэсэг, 14 дүгээр гудамж, Ус түгээх байр | 43,822,273 |
| 4 | ЧД-ийн 14 дүгээр хороо, Хайлаастын 24 дүгээр гудамж, Ус түгээх байр | 40,000,000 |
| 5 | ЧД-ийн 19- хороо, Доод Салхитын 2-Б тоот хашааны урд Ус түгээх байр | 44,171,942 |
| 6 | Налайх дүүргийн 5 дугаар хороо, Хүүхэд хөгжлийн төвийн барилга | 2,778,965,661 |
| 7 | НД-ийн 5 дугаар хороо, Ус түгээх байр | 18,000,000 |
| 8 | НД-ийн 6 дугаар хороо, Болорын хэсэг, Гүний худаг | 10, 000,000 |
| 9 | НД-ийн 7 дугаар хороо, Өвөршандын хэсэг, Гүний худаг | 10,000,000 |
| 10 | СХД-ийн 21 дүгээр хороо, Бие засах газрын барилга | 48,281,080 |
| *Дүн: 7,999,187,984 төгрөг* | | |
| *НИТХТ-ийн 2017 оны 171 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/93 дугаар захирамж* | | |

| | | |
|---|---|---|
| 1 | БГД-ийн 8-р хороо “Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн” цогцолбор барилга | 1,512,156,083 |
| 2 | БГД-ийн “Ахмад настны нөхөн сэргээх эмчилгээ, сувиллын төв, хүүхдийн эмнэлэг”-ийн барилга байгууламж | 3,693,818,546 |
| 3 | БГД-ийн 11 дүгээр цэцэрлэгийн барилга байгууламж | 1,496,810,314 |
| 4 | БГД-ийн 77 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж | 692,998,750 |
| | *Дүн: 7,395,783,693 төгрөг* | |
| | *НИТХТ-ын 2018 оны 02 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/95 дугаар захирамж* | |
| 1 | Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Түргэн тусламжийн төвийн барилга байгууламж | 2,681,781,116 |
| | *Дүн: 2,681,781,116 төгрөг* | |
| | *НИТХТ-ын 2018 оны 39 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/385 дугаар захирамж* | |
| 1 | ЧД-ийн 18-р хороо, 150 хүүхдийн ортой Цэцэрлэгийн барилга байгууламж | 1,029,482,816 |
| 2 | ЧД-ийн 12р хороо, Жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилга байгууламж | 1,284,573,471 |
| | *Дүн: 2,314,056,287 төгрөг* | |
| | *НИТХТ-ийн 2018 оны 63 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/479-р захирамж* | |
| 1 | БЗД-ийн 10-р хороо, Улаан хуаран гудамж, Ус түгээх байр | 43,639,893 |
| 2 | БЗД-ийн 12-р хороо, Жанжины 11-р гудамж, Ус түгээх байр | 43,704,218 |
| 3 | СХД-ийн 22-р хороо, Хилчний 44-р гудамж, Ус түгээх байр | 39,652,717 |
| 4 | ЧД-ийн 7-р хороо, Хувьчгалчдын –Г гудамж, Ус түгээх байр | 38,763,362 |
| 5 | ЧД-ийн 12-р хороо, Булгийн 19-р гудамж, Ус түгээх байр | 43,700,474 |
| 6 | ЧД-ийн 16-р хороо, Согоотын 52-р гудамж, Ус түгээх байр | 47,453,967 |
| | *Дүн: 256,914,631 төгрөг* | |
| | *Дүн: 4,288,629,229 төгрөг* | |
| | *Нийт дүн: 20.647.723.711 төгрөг* | |

2. Баянгол дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулан, нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж байгаа **598,807,720** төгрөгийн үнэ бүхий 1.0 км авто замыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 62 дугаар тогтоол, НЗД-ын 06 дугаар сарын 05-ны өдрийн А/512 дугаар захирамжаар нийслэлийн өмчид бүртгэх шийдвэрийг гаргуулан тус ажлыг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулсан.

### *3. Тээврийн хэрэгсэл*

| | | |
|---|---|---|
| | *НЗД-ын 2018 оны А/25* | |
| 1 | Nissan Teana, Toyota Pruis маркийн суудлын авто машин 2 ширхэг | 78,300,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/26 дугаар захирамж* | |
| 1 | Хот тохижилтын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 2 ширхэг | 887,900,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/94 дүгээр захирамж* | |
| 1 | ЧД-ийн 5 өрхийн эрүүл мэндийн төвд тээврийн хэрэгсэл | 69,930,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/248 дүгээр захирамж* | |
| 1 | “Хюндэй Старекс” маркийн микроавтобус | 20,000,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/369* | |
| 1 | Сургуулийн автобус 3 ширхэг | 398,000,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/500 дугаар захирамж* | |
| 1 | HOWO маркийн өөрөө буулгагч автомашин, DONGFENG маркийн крантай автомашин, B75W8, FUJIAN маркийн дугуйт экскаватор /3 ш/ | 363,000,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/596 дугаар захирамж* | |
| 1 | Нийслэлийн Цагдаагийн газрын балансад 17 ширхэг автомашин | 777,580,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/638 дугаар захирамж* | |
| 1 | Бульдозер /Тусгай зориулалтын механизм/ 3 ширхэг | 998,940,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/778 дугаар захирамж* | |
| 1 | Nissan Teana маркийн автомашин 1 ширхэг | 50,000,000 |
| | *НЗД-ын 2018 оны А/853 дугаар захирамж* | |
| 1 | “Хюндэй Старекс” маркийн микроавтобус | 24,100,000 |
| | *Нийт дүн: 3,667,750,000 төгрөг* | |

4. Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийтийн эзэмшлийн хөрөнгө, их засварын **3,146,245,926** төгрөг бүхий НЗД-ын 2017 оны захирамжаар шийдвэрлүүлсэн 9 ажлыг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулсан.

5. ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр бүртгэсэн эд хөрөнгө

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **145** байгууллагын **2,726,06 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаал батлуулсан. Үүнд:

- ✓ Багануур дүүргийн 8 байгууллагын 42.78 сая төгрөг
- ✓ Налайх дүүргийн 4 байгууллагын 13.92 сая төгрөг
- ✓ Баянгол дүүргийн 31 байгууллагын 546.60 сая төгрөг
- ✓ Баянзүрх дүүргийн 40 байгууллагын 694.59 сая төгрөг
- ✓ Сонгинохайрхан дүүргийн 12 байгууллагын 81.10 сая төгрөг
- ✓ Сүхбаатар дүүргийн 25 байгууллагын 509.85 сая төгрөг
- ✓ Хан-Уул дүүргийн 13 байгууллагын 347.03 сая төгрөг
- ✓ Чингэлтэй дүүргийн 12 байгууллагын 490.15 сая төгрөг

6. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд авах тухай албан бичиг хүргүүлсэн талаар:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Авто замын хөгжлийн газар зэрэг захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, авто зам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт **8,592,94 сая** төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон **87** албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн.

“Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон **5,915.5 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэлд авсан шийдвэрийг **165** байгууллага ирүүлснийг хүлээн авч судалгаанд хамруулав.

ЭБХХХК-ын шийдвэрээр 12 байгууллагын 34,77 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд, 12 байгууллагын 303,92 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд, 9 байгууллагын 270,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэх буюу дансны залруулга хийх 33 тушаал гарган хүргүүлсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орж буй барилга байгууламжийг ашиглалтад оруулах, их засварын ажил хүлээн авах нийт ***11,880,16 сая*** төгрөгийн төсөвт өртөг бүхий **108** комиссын бүрэлдэхүүнд орж дүүрэг хариуцсан мэргэжилтнүүд санал, дүгнэлт өгч ажилласан.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2018 онд санхүүжих
496 төсөл арга хэмжээний судалгааг харуулбал:

- ✓ НТХО-аар хийгдэх – 70.5 тэрбум төгрөгийн 191 ажил
- ✓ Замын сангийн – 24.0 тэрбум төгрөгийн 66 ажил
- ✓ НОНХС-ийн – 9.5 тэрбум төгрөгийн 164 ажил
- ✓ УТХО-аар – 53.3 тэрбум төгрөгийн 75 ажил

### *3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар:*

Тайлант хугацаанд санал ирүүлсэн 29 байгууллагын хүсэлтийн дагуу нийт **22,919,886,196.9** төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын балансад шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлсэн. Үүнд:

*Барилга, байгууламж*

| *НИТХТ-ийн 2018 оны 73-р тогтоол, НЗД-ын 2018 оны А/723 дугаар захирамж* | |
|---|---|
| “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын балансад хөрөнгө | 18,286,983,909 |
| *НИТХТ-ийн 2018 оны 89-р тогтоол, НЗД-ын 2018 оны А/635 дугаар захирамж, газрын даргын 2018 оны А/404 дүгээр тушаал* | |
| “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын балансад 2 давхар конторын барилгыг | 67,560,000.0 |
| *НИТХТ-ийн 2018 оны 106-р тогтоол, НЗД-ын 2018 оны А/667 дугаар захирамж* | |
| БГД-ийн 5-р хороо, Дэшиг Дун, 6-р хорооны Мөнх-Үжин ӨЭМТ-ийн барилгыг НӨХГ-ын балансад | 168,648,032 |
| *НИТХТ-ийн 2018 оны 107-р тогтоол, НЗД-ын 2018 оны А/735 дугаар захирамж* | |
| Багахангай дүүргийн “Хот тохижилтын алба” ОНӨААТҮГ-ын балансад барилга, байгууламж | 17,986,400.0 |
| *НИТХТ-ийн 2018 оны 108-р тогтоол, НЗД-ын 2018 оны А/716 дугаар захирамж* | |
| ЧД-ийн 9-р хороо, 43-р цэцэрлэгийн барилгыг 174-р цэцэрлэгийн балансад | 124,000,000 |
| *НИТХТ-ийн 2018 оны 136-р тогтоол* | |
| СБД-ийн 16-р хорооны “Мандам” ӨЭМТ-ийн балансад бүртгэлтэй барилгыг НӨХГ-ын балансад | 17,100,000 |
| *Нийт дүн: 18,682.278.341 төгрөг* | |

*Тээврийн хэрэгсэл*

| *НЗД-ын 2017 оны А/81 дүгээр захирамж* | |
|---|---|
| Нийслэлийн тээврийн газарт Соната-6 маркийн автомашин | 15,000,000 |
| *НЗД-ын 2018 оны А/852 дугаар захирамж* | |
| “Нийтлэг үйлчилгээний газар нэг” ОНӨААТҮГ, “Нийтлэг үйлчилгээний газар гурав” ОНӨААТҮГ-т 2 тээврийн хэрэгсэл | 168,000,000 |
| *Нийт дүн: 183,000,000 төгрөг* | |

*ЭБХХХК-ын хурлаар*

| *НӨХГ-ын даргын 2018 оны А/54 дүгээр тушаал* | |
|---|---|
| СХД-ийн ӨЭМТ-үүдийн балансад 32 ширхэг компьютер | 55,564,128.96 |
| *НӨХГ-ын даргын 2018 оны А/277 дугаар тушаал* | |
| “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын балансад үерийн хамгаалалтын системийн барилга, байгууламж | 2,979,810,946 |
| *НӨХГ-ын даргын 2018 оны А/230 дугаар тушаал* | |
| ОСНААУГ-ын балансад шугам сүлжээ, тоног төхөөрөмж | 1,019,232,781 |
| *Нийт дүн: 4,054,607,855.96 төгрөг* | |

### *3.2.3. Данснаас хассан хөрөнгийн талаар*:

2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт **15,964,106,009.9** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 39 нэрийн барилга байгууламжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг НИТХТ-ийн тогтоол, НЗД-ын захирамжаар шийдвэрлүүлсэн.

*Барилга байгууламж:*

1. Монгол Улсын төсвийн тухай хуулийн улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад нийслэлд “Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”, “Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөр”-д цэцэрлэг, сургуулийн барилга баригдахаар тусгагдсан байна.

Үүнд:

| | | |
|---|---|---|
| *НИТХТ-ийн 2018 оны 15 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/247 дугаар захирамж* | | |
| 1 | СХД-ийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн эрүүлжүүлэхийн байр, гаражийн барилга | 144,834,240 |
| *НИТХТ-ийн 2018 оны 39 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/385 дугаар захирамж* | | |
| 1 | ЧД-ийн 12-р хороо, ӨЭМТ-ийн барилга, 18-р хороо, цэцэрлэгийн барилга | 2,314,056,287 |
| *НИТХТ-ийн 2018 оны 41 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/377 дугаар захирамж* | | |
| 1 | БЗД, ХУД-ийн 2 барилга байгууламж | 1,549,606,235.5 |
| *НИТХТ-ын 2018 оны 42 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/378 дугаар захирамж* | | |
| 1 | БЗД-ийн  21-р сургуулийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө | 1,971,507,775.6 |
| 2 | БЗД-ийн  50-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө | 393,868,705.6 |
| 3 | БЗД-ийн  59-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө | 426,531,625.0 |
- Эх үрсийн баярыг угтсан арга хэмжээ;
- Нийслэлийн өмчит төсөвт байгууллага, үйлдвэрийн газруудын анхааралд;
- Тэргүүний өмч эзэмшигч байгууллагуудыг шалгаруулсан талаар;
- “Хуучнаар 50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн барилгын дээврийн засвар болон гадна засварын ажил”-ын тендерийн урилга;
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэх урилга;
- Нийслэлийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулалтын нийт  10 сургуулийн зар;
- “Зорчигч тээвэр гурав” ӨНӨААТҮГ-ын ажилчдын цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай;
- Үдийн цай хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад шалгарсан байгууллагын талаарх мэдээлэл;
- Түрээсийн загвар гэрээ хавсралтын хамтаар татаж авахаар;
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын Өмч эзэмшлийн загвар гэрээг хавсралтын хамтаар татаж авахаар;
- Хөрөнгийн үнэлгээний байгууллагуудад нээлттэй тендер зарласан тухай;
- Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааны зар ;
- “Үзэсгэлэнт Улаанбаатар цом” нэг бүс нэг зам Монгол-Хятадын өртөөт Марафонд баг хамт олноороо амжилттай оролцсон талаар ;
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлын сургалтын хөтөлбөр

Мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлууд:

- Антивирусийн программын захиалгыг хийж гэрээг байгуулан, нийт албаны компьютерийн вирусийн программын эрхийг сунгасан.
- Байгууллагын нийт албан хаагчдын байгууллагын и-мэйл хаягийн хэрэглээ, байнгын ажиллагааг хангасан.
- Нийслэлийн мэдээлэл технологийн газрын 2018.04.19-ны 01/210 тоот албан бичгийн дагуу байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй программ хангамжийн судалгааг маягтын дагуу нэгтгэн 1/785 тоот албан бичгээр хүргүүлэв
- Монгол Улсын Засгийн газрын 2018.05.23–ны өдрийн 138 дугаар тогтоол, НЗД-ын 2018.06.04-ний өдрийн А/509 дүгээр захирамжийг байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн олон нийтийн сүлжээ болох Youtube.com, Facebook.com, Instagram.com, twitter.com зэрэг сайтуудад нэвтрэх эрхийг хаалаа.

### *4.2. Хяналт шалгалтын ажлын талаар:*

- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Дамбадаржаа хийдийн халаалтын зуухын барилга, Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт /71 дүгээр сургуулийн ард/ байрлах халуун усны барилга, Баянгол Сэлбэ амралтын барилгын байдалтай газар дээр нь очиж танилцаж барилга байгууламжийн тухай илтгэх хуудсаар танилцуулсан. Орон сууцны конторуудаас хандиваар өгсөн халаалтын зуухыг Дамбадаржаа хийдийн балансаас Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын балансад бүртгэн авах, Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт /71 дүгээр сургуулийн ард/ байрлах халуун усны барилгын ашиглалтыг сайжруулах, Баянгол Сэлбэ амралтын газрын ашиглалт хамгаалалтыг сайжруулах замаар Асгат ОНӨААТҮГ-т гэрээгээр ашиглуулах зэрэг саналыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.
- Баянгол дүүргийн ЗДТГ-ын балансад бүртгэлтэй барилга байгууламжийн дэлгэрэнгүй судалгаа болон тус дүүргийн 23 хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга болон хуучин барилгын ашиглалтын судалгааг гарган удирдлагад танилцуулсан.
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй Гэр бүл, ёслолын ордон, Усан спорт сургалтын төв, Хүүхэд залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ-ын барилгатай газар дээр нь очиж танилцан байр ашиглалтын байдлын талаар Илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.
- Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу НЗДТГ-ын 2018.02.05-ны өдрийн 03/429 дугаар албан бичгээр ирүүлсэн ажлын хэсгийн зөвлөмжид заасан 12 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэг бүрчлэн тулган шалгаж удирдлагад Илтгэх хуудсаар танилцуулсан.
- Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх болон байгууллагын 2018 оны эхний хагас жилийн тайланд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай ажлуудын хэрэгжилтийг ханган ажиллах газрын даргын №5 даалгаврыг боловсруулж газрын даргаар батлуулан хэлтсүүдэд хүргэсэн.
- Шилэн дансны тухай хуулийг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд Төсвийн тухай хууль , Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажилласан байна. Үүнд:
  - Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт : Орлогын дүн 648,309,122.8 төгрөг, урсгал зардал 467,994,200.0 төгрөг,
  - Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт: тайлант хугацаанд төсвийн өөрчлөлт ороогүй,
  - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ: Төрийн санд түрээсийн орлого 105,833,895.3 төгрөг,
  - Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл: тайлант хугацаанд ажил, үйлчилгээ байхгүй
  - Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл: Урт цагаан үйлчилгээний төвийн дээврийн засварын ажил 15,535,725.0 төгрөг,
  - Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг: 20 гүйлгээний 173,334,184.2 төгрөгийн мэдээллүүдийг оруулсан байна.

### *4.2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын талаар*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу байгууллагын 1, 2, 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ, үнэлгээ хийж Илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.

Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, тайлан, мэдээг цаг хугацаанд нь гүйцэтгэх, байгууллага хэлтсийн хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг загварын дагуу боловсруулах зэрэг дараах саналуудыг хэлтсүүдэд хүргүүлэхээр тусгасан: Үүнд:

- НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 9.1-д заасны дагуу эрэмбэлэн тайлан гаргах,
- Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь захиргаа санхүүгийн хэлтэст гарын үсгээр баталгаажуулан хүргэх, тайланд хэрэгжилтийн явцыг оруулах,
- дээрх журмын 8.6.7-д заасны дагуу байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжээр тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайланд шинжилгээ хийлгэж, баталгаажуулах,
- Imonitoring-д 90%-аас доош үнэлгээтэй оруулсан тогтоол, захирамжийн хэрэгжилтийг дахин шалгах,
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын даргын үр дүнгийн гэрээний зорилтод тусгагдсан дутуу биелэлттэй, хэрэгжүүлж эхлээгүй ажлыг эрчимжүүлэх, цаг хугацаанд нь гүйцэтгэн тайланд тусгах
- Байгууллагын газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг бүр ажлын тайланг өгч хэвших, хэлтсийн тайланд оруулах,
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 4-т заасны дагуу баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих,
- Хэлтсүүд мэдээ, тайлан гаргахдаа зөв бичгийн дүрмийн, эдийн засгийн үзүүлэлтийн болон техникийн алдаа гаргахгүй байх

➢ Газрын даргын 2013 оны Б/67 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлах тухай” журам нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын зарим заалтыг зөрчин гарсан байх тул Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хүчингүй болгох санал оруулсан.

➢ Нийслэлийн өмчит сургуулиудын 2017-2018 оны хичээлийн жилд “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэх цайны газар түрээслэгч аж ахуй нэгжийг сонгон шалгаруулахтай холбогдон маргаан гарсан 6 сургуулийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн аж ахуй нэгжийн материалуудыг шалган Илтгэх хуудсаар газрын даргад танилцуулж холбогдох шийдвэрийг сургуулиудад хүргүүлж ажилласан.

### *4.3 . Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар:*

Тайланд хугацаанд анхан шатны шүүхэд хянагдаж байгаа 8, давж заалдах 2, хяналтын шатны шүүх дээр 1, шийдвэр гүйцэтгэлийн шатанд 4 маргаантай асуудлууд хянан шалгагдаж байна. Үүнд:

- ✓ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг төлөөлж 3
- ✓ Нийслэлийн Засаг даргыг төлөөлж 2
- ✓ Нийслэлийн Өмчийн харилцааны газрыг төлөөлж 9 хэрэгт хариуцагчаар оролцсон.




*Аж ахуй нэгж байгууллага иргэдээс ирүүлсэн өмч хөрөнгөтэй холбогдолтой маргааныг шийдвэрлэх ажлын талаар*

Анхан шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Гуравдагч этгээд | Нэхэмжлэлийн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Анома” ХХК | НИТХ, НӨХГ | - | - 3,065,000,392 төгрөгийн нэхэмжлэлтэй<br>- 2004 онд “Анома” ХХК нь “Урт цагаан үйлчилгээний төв”-ийн 2, 3 дугаар блокт 477,304,107 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, засаж сайжруулж шинэ өмч хөрөнгө бий болгосон,<br>- 2016 онд “Лэндс” ХХК-ийн шинжээчийн дүгнэлтээр уг барилгын үнэлгээ 3,983,463,781 төгрөг болсон, үүнээс “Анома” ХХК-ны оруулсан хөрөнгө 87.43% буюу 3,482,742,384 төгрөг энэ үнээс НӨХГ-т урьд нь гарсан шүүхийн шийдвэрийн дагуу 417 741 992 төгрөг /түрээсийн төлбөр/ хасч, үлдэх 3,065,000,932 төгрөгийг нэхэмжилж байгаа болно. | ЧД-ийн ИХАШШ- хянагдаж байна. Шүүгч Дашдэчмаа |
| 2 | “Хар чонот” ХХК | НИТХ, НЗД | - | - “Урт цагаан үйлчилгээний төв”-ийн 5, 6 дугаар блок нийт 472 м2 талбай бүхий байрыг НИТХ-ын 2002 оны 7/36, 2007 оны 11/65 дугаар тогтоол, ТӨХ-ны 2008 оны 191 дүгээр тогтоолыг тус тус биелүүлж уг байрыг хувьчилж өгөхийг шаардсан нэхэмжлэлтэй. | НЗХАШ шүүхэд хянагдаж байна. Шүүгч Төмөрбат |
| 3 | “Жи Эй Би Өү Ти” ХХК | НИТХ | ОСНААУГ | - “Буянт- Ухаа” 1,2 дугаар хорооны УДДТөв-д холбогдох НИТХ-ын 2016 оны 25 дугаар тогтоол хэрэгсэхгүй болгох тухай | НЗХАШ шүүхэд хянагдаж байна. Шүүгч Дуламсүрэн |
| 4 | Зорчигч тээврийн нэгтгэл-ийн ҮЭХороо | НЗД | - | - НИТХ-ын 2018 оны 24/05, НӨХК-ын 16 дугаар тогтоолуудыг хүчингүй болгох | НЗХАШ шүүх 2018.03.19 нд 176 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. |
| 5 | Н.Баасанжав | НӨХГ | | - Дэнчингийн 24,6 сая төгрөг нэхэмжилсэн. | СБД шүүхэд хянагдаж байна. |
| | Б.Пүрэвдорж | НӨХГ | | Газрын маргаан | Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | “Эрдэнэ суварга”ХХК | НӨХГ | | ЧД-ийн 10-р хороо, ус дулааны станцын асуудал | Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байна |
| | Б.Төрбиш | НӨХГ | | Газрын асуудал | ЧД-ийн анхан шатны шүүхэд хянагдаж байна. |

Хяналтын шатны шүүхээр хянагдаж байгаа хэргийн мэдээ

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Гуравдагч этгээд | Нэхэмжлэлийн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Ган хийц” ХХК | НӨХГ | - | 13 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын тухай | - СХД-ийн шүүх, 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 00202 шийдвэрээр, Нийслэлийн ДЗШШ-ээс 2018 оны 03 дугаар сарын 19-нд шийдвэрт өөрчлөлт оруулж 13 сая төгрөгийг СХД-ийн ЗДТГ-аас гаргахаар шийдвэрлэсэн<br>- Одоо УДШ-д СХД-ийн ЗДТГ гомдол гаргасан байгаа. |

Давж заалдах шатанд хянагдаж байгаа хэргийн мэдээ

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Гуравдагч этгээд | Нэхэмжлэлийн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэн Уранзаяа | НӨХГ | - | - “Улаанбаатар сан” ОНӨААТҮГ-т нарийн бичиг, архивчаар ажиллаж байсан ажилтан 5,344,062 төгрөгийг нэхэмжилсэн | ЧД-ийн ИХАШШ-ын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 00480 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. |
| 2 | Иргэн М.Отгон жаргал | НӨХГ, НГА | - | - 9,177.205 төгрөгийг нэхэмжилсэн /Ажилд эгүүлэн тогтоох/ | - НЗХАШШ-ын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 0093 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг хангаж 9.1 сая төгрөгийг олгож, ажилд нь эгүүлэн тогтоохыг НГА-д даалгасан.<br>- Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож анхан шатны шүүхэд буцаасан. |

## Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мэдээ

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Гуравдагч этгээд | Нэхэмжлэлийн утга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | НӨХГ | МАН | - | 810 сая төгрөгийн түрээс | - СБД-ийн шүүхийн 2013 оны 613 дугаар шийдвэрээр МАН-аас 522 сая төгрөгийг НӨХГ-т олгон, гүйцэтгэл 100 сая төгрөг, үлдэгдэл 422 сая төгрөг. |
| 2 | НӨХГ | “Анома” ХХК | - | Түрээсийн төлбөр 417.7 сая төгрөг нэхэмжилсэн | - 2013 оны ЧД-ийн шүүхийн 480 дугаар шийдвэрээр “Анома” ХХК-аас 417.7 сая төгрөгийг НӨХГ-т олгосон<br>- 2018 оны 4 сарын байдлаар шийдвэр огт биелэгдээгүй.Уг төлбөрийг “Анома” ХХК нь 477.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дүнд тооцно, эсвэл одоогийн байдлаар ЧД-ийн ИХАШШ-ээр хянагдаж байгаа иргэний хэргийн 3.0 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгээс хасч тооцно гэсэн тайлбартай байгаа. |
| 3 | “Улаанбаатар” банк | Багахангай дүүргийн “Мах боловсруулах” үйлдвэр | - | 501.0 сая төгрөг нэхэмжилсэн. | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд ажиллагаа хийгдэж байгаа.<br>- /70.0 сая төгрөг төлсөн./ |
| | М.Отгонжаргал | НӨХГ | | 9,1 сая төгрөгийг | - УДШ-ийн тогтоолоор 9,1 сая төгрөгийг М.Отгонжаргалд олгох |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | НӨХГ-аас нэхэмжил сэн | |

## ТАВДУГААР БҮЛЭГ.
## "БУСАД МЭДЭЭЛЭЛ"

### *5.1.Нийслэлийн төсөвт байгууллагууд, НӨҮГ-ууд болон бусад байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:*

- ✓ Нийслэл Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Замын Цагдаагийн газрын ойролцоо гүүрэн гарц барих төслийн нөлөөлөлд өртөж байгаа Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн /ҮСАХ/ ХХК-ийн газрыг чөлөөлөх шаардлага гарсан ҮСАХ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг НИТХТ-ын хурлаар хэлэлцүүлэн НИТХТ-н 2018 оны 27 дугаар тогтоолоор гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулсан. "Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулан, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд "Замын Цагдаагийн газрын баруун урд уулзварыг олон түвшний огтлолцол бүхий гүүрэн гарц барих ажил дуустал нийслэлийн эзэмшиж буй давуу эрхийн хувьцаанд жил бүр олгодог ногдол ашгаас чөлөөлөх, гүүрэн гарц барих ажлыг саадгүй явуулж, нөлөөлөлд өртөж буй газрыг чөлөөлөх зэрэг нэмэлт өөрчлөлтийг оруулан, 2018.05.02-ны өдөр баталгаажуулсан.
- ✓ НЗД-ын 2007 оны "Нийслэлийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах тухай" 555 дугаар захирамжийн дагуу "Өргөө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, "Дун Өргөө" ХХК-ийг байгуулахад "Хар Дун" ХХК-ийн 75 хувьд ногдох хөрөнгө оруулалтыг баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ НЗД-ын Зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээр "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-т 2018 онд хийж хэрэгжүүлэх худалдаа, үйлчилгээ эрхлэх "Төсөл хэрэгжүүлэгч баг" сонгон шалгаруулах журам батлуулж ажиллахыг үүрэг болгосонтой холбогдуулан тус үйлдвэрийн газрын даргын 2018 оны А/12 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хариуцсан мэргэжилтэн орж ажилласан. Төсөл сонгон шалгаруулах комиссын шийдвэрээр спорт талбайн үйл ажиллагааг эрхлэхээр "Изи консалтинг" ХХК, спорт талбайн урд хэсгийн 153 м2 талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэхээр "Red film" ХХК, болон "Энержи байк" ХХК-ийн ирүүлсэн төслийг тус тус шалгаруулж хамтран ажиллахаар болов.
- ✓ Татан буугдсан "Ионсей найрамдал эмнэлэг" ХХК-ны Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст төлөх үлдэгдэл төлбөр ***4,431.0*** сая төгрөгийг төвлөрүүлэн өр төлбөргүй талаар албан бичиг авч дүүргийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж өр төлбөргүй талаар албан бичиг авсан. Улсын бүртгэлээс хасуулахад шаардагдах дараалын дагуу Голомт банкны дансыг хаалгуулан, хаалтын баланс гаргуулж байна.
- ✓ Татан буугдсан "Уламжлалт эм эмийн ургамал компани" ОНӨААТҮГ-ын хаалтын баланс гарган Баянзүрх дүүргийн Төрийн сангаар баталгаажуулах, тус үйлдвэрийн газрыг бүртгэлээс хасуулах үүднээс дүүргийн Татварын хэлтэст Үл хөдлөх хөрөнгийг бүртгэлээс хасуулах, Хяналт шалгалтын актуудаар ногдуулсан хүү торгуулийн алдангийг "Өршөөлийн хууль"-д хамруулах талаар 2/308, 2/309, 2/310 тоот албан бичиг хүргүүлж, төлбөр тооцоогүй талаар албан бичиг авахаар хүлээгдэж байна.
- ✓ Багахангай мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд үүссэн нөхцөл байдалтай танилцан, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид шийдвэрлэх санал боловсруулах үүрэг бүхий НЗД-ын 2018 оны А/220 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Налайхын дүүргийн шийдвэр гүйцэтгэх хэсгээс Улаанбаатар хотын банкны зээлийн барьцаанд хураан авсан үйлдвэрийн талаар болон шүүхийн шийдвэрийн талаар танилцуулга бэлтгэн, холбогдох материалын хамт ажлын хэсэгт хүлээлгэн өгч НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

- ✓ Хувийн хөрөнгө оруулалттай Олонлог бүрэн дунд сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн барилга, газар эзэмшилт, биеийн тамирын талбай, номын сангийн талаар судлан, танилцуулга бичиж хүргүүлсэн.
- ✓ Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-аас ирүүлсэн Зайсан толгой дахь нийтийн эзэмшлийн зам талбайд байрлах төлбөртэй зогсоолын барилгыг “СОБТ трейд” ХХК-д шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж, Зөвлөлтийн дайчдад зориулсан дурсгалын хөшөө цогцолбор нь НИТХТ-ийн 2007 оны 197 дугаар тогтоолоор түүх соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад багтсан тул НӨХГ-ын 2018 оны 2/297 тоот албан бичгээр холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвшөөрөл авахыг мэдэгдсэн.
- ✓ Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй ундны усны дээд эх үүсвэрт байрлах уурын зуухыгг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газарт шилжүүлэх боломжтой эсэх талаар газар дээр нь танилцуулах ажлыг зохион байгуулсан.
- ✓ “УБ хотын даатгал” ХХК-ны хувьцаа худалдах санал ирүүлснийг мөн тус байгууллагад Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018.03.01-ний өдрийн 3/773 тоот албан бичгээр Даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 5.0 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөө, тайлбарыг 2018.03.15-ны дотор ирүүлэх шаардлага ирүүлсэн байна. Энэхүү тогтоолын хүрээнд компаниас шинээр гаргах хувьцааг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас худалдан авч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувиа нэмэгдүүлэх талаар санал ирүүлсэн бөгөөд удирдлагуудад тус саналыг байгууллагын талаарх танилцуулгын хамт боловсруулан танилцуулсан.
- ✓ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын талбайд “Худалдаа, үйлчилгээ эрхлэх журам”-ыг шинэчлэх шаардлагын дагуу журмын төсөлтэй танилцан санал хүргүүлсэн.
- ✓ “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн найруулж, боловсруулан, байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн НИТХТ-ийн хуралд өргөн барихаар бэлэн болгосон.
- ✓ НИТХТ-ийн 2017 оны 123 дугаар тогтоол, НЗД-ын 2017 оны А/865 дугаар “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” захирамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НӨХГ-ын даргын 2017 оны А/781 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлыг 2018.02.07-ны өдөр хуралдуулж, ОСНААУГ-т БЗД-ийн 4 дүгээр хорооны Нарны замын 81-р байр, ХУД-ийн 11 дүгээр хорооны 85А, Б байр, БГД-ийн 7 дугаар хороо, Пром-36 байр гэсэн 4 байрны шугам сүлжээ, БЗД-ийн 13 дугаар хороо, 116 дугаар байрны үнийн дүнгийн зөрүү, давхардаж орсон БЗД-ийн 2 дугаар хорооны 64/2 байрны нийт **373,548,932.0** төгрөгийн хөрөнгийг хасч, **5,340,805.0** төгрөгийн хөрөнгө хүлээн авсан акт ирүүлэхийг шийдвэрлэсэн.
- ✓ НИТХТ-ийн 2017 оны 125 дугаар тогтоол, НЗД-ын 2017 оны А/864 дүгээр “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” захирамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЗД-ын 2017 оны А/953 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлыг 2018.01.24-ний өдөр хуралдуулан захиалагч, гүйцэтгэгч, эзэмшигч байгууллагуудын инженерүүдтэй хамтарч нийт инженерийн байгууламжийн чанар байдлын талаар дүгнэлт гаргасан. Үүнд:
    - Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооллын 1,573,197,391 төгрөгийн өртөг бүхий Ус дулаан дамжуулах 6 төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ОСНААУГ-т,
    - Сонгинохайрхан дүүргийн Ханын материал орчмын 800,499,364 төгрөгийн өртөг бүхий Ус дулаан дамжуулах төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-т,
    - Хан-Уул дүүргийн Яармаг хорооллын 2,703,422,000 төгрөгийн өртөг бүхий бохир усны шугам, насос станцын барилга байгууламжийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т
    - Мөн Сонгинохайрхан дүүргийн Баянголын амны Ус дулаан дамжуулах 1 төвийн барилга, тоног төхөөрөмжийг ОСНААУГ-т хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн.

### *Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх ажлын талаар:*

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулах

бэлтгэл ажлын хүрээнд ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/110 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, Монгол улсад байгаа болон гадаад улс оронд байгаа төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал, заавар, журам, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.

ТӨБЗГ-аас 2018.0.18-19-ний өдрүүдэд “Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл, 2017 оны улсын нэгтгэлд анхаарах асуудлууд”, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх сиситемийн танилцуулга” сургалтыг зохион байгуулж холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан. Хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмжийг 9 дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2018 оны 3/180, 3/217-3/224 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн.

НЗД-ын 2017.09.28-ны өдрийн А/713 дугаар захирамжаар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэн, санхүүгийн тайланд тусгах болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын бэлтгэлийг хангаж 2018 онд багтаан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлыг 2018.09.17-ны өдөр хуралдуулсан.

ТӨБЗГ-аас дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018 оны 273 дугаар тогтоолыг гаргасан бөгөөд тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт доорх үүрэг даалгаврыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2018.06.28-ны өдрийн 3/1061 тоот албан бичгээр нийслэлийн өмчит 758 байгууллагад хүргүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэх
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан хөрөнгийн ангиллын кодыг хөтөлж хэвшүүлэх
- “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д мэдээллээ оруулах

Сангийн сайдын 2018.08.07-ны өдрийн 207 дугаар тушаалаар үнэлгээ хийх аргачлалуудыг, ТӨБЗГ-ын 2018.08.14-ний өдрийн 367 дугаар тогтоолоор үнэлгээний ажлыг зохион байгуулах зааврыг тус тус баталсан болно.

Мөн ТӨБЗГ-ын 2018 оны 367 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар батлагдсан аргачлал, зааврын дагуу дахин үнэлгээний ажлыг орон нутагт зохион байгуулж, нэгдсэн тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг нийслэлийн Өмчийн харилцааны газар, аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус даалгасан байна.

ТӨБЗГ энэ удаагийн төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээний ажлын анхны сургалтыг 2018 оны 9 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд нийслэлийн Өмчийн харилцааны газрын болон аймгуудын өмчийн газрын холбогдох албан тушаалтнуудыг хамруулан зохион байгуулсан. Манай байгууллагаас ТӨБЗГ-тай хамтран нийслэл, дүүргийн өмчит хуулийн этгээдүүдэд зориулан дахин үнэлгээний сургалтыг 2018.09.27-28-ны өдрүүдэд зохион байгуулан хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг эхлүүлсэн.

### *Бусад ажлын талаар*

✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын баталсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Улаанбаатар хотын захирагчийн харьяа газруудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын удирдамжийн дагуу 2018.01.10-19-ний өдрүүдэд шалган зааварлах ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнүүд ажиллан Захирагчийн харьяа аж ахуйн тооцоот 20 байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалт, Контрактын биелэлттэй танилцаж, үнэлэлт өгч ажилласан.

- ✓ НЗД-ын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2017 оны А/772 дугаар захирамжийн хүрээнд НЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2018.02.21-26-ны өдрүүдэд “Зорчигч Тээврийн Нэгтгэл” ОНӨААТҮГын 2016, 2017 онд Хөдөлмөрийн гэрээ цуцлагдан халагдсан ажилтан албан хаагчдад олгосон тэтгэмж, өндөр настны тэтгэмж авахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан ажиллагсдад шүүхийн шийдвэрийн дагуу тэтгэмж олгосон болон 2017 оны НЗД-тай байгуулсан Контрактын биелэлттэй танилцаж шалгалаа. Тус ажлын хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд илтгэх хуудас, дүгнэлт боловсруулан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- ✓ НЗД-ын 2018 оны “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/87 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх Устгалын комиссод холбогдох мэргэжилтнүүд орж ажиллан 370,3 сая төгрөгийн хөрөнгийг устгасан бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн 29 дүгнэлт, шийдвэрийн дагуу албадлагын журмаар хураасан эд зүйл /1700 ширхэг архи, тамхи/-ийг үнэлсэн.
- ✓ “Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2017 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан “Улсын нийслэлд хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбар байрлуулах” үүрэг бүхий ажлын хэсгийн хуралд холбогдох мэргэжилтнүүд 2 удаа оролцож хэлэлцсэн асуудлуудад саналаа өгсөн.
- ✓ Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2018 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан “175 ширхэг агаар цэвэршүүлэгчийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөх” үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж журмын дагуу 175 ширхэг агаар цэвэршүүлэгчийг хүлээн авсан.
- ✓ Нийслэлийн өмчийг 2018-2020 онд хувьчлах өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг боловсруулан, НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.
- ✓ “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах” хуулийн дагуу орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар зохион байгуулсан 48 үнэлгээний хороонд холбогдох мэргэжилтнүүд ажиллан санал дүгнэлтээ тусгуулсан.
- ✓ Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглалтад хүлээн авах 26 комиссод орж ажиллан, санал дүгнэлтээ өглөө.
- ✓ НЗД-ын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/156, Б/157 дугаар захирамжаар “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга Н.Батсүмбэрэлийг ажлаас чөлөөлж, Д.Хатанбаатарыг ажилд томилох шийдвэр гарсантай холбогдуулан “Ажил хүлээлцүүлэх” ажлын хэсэгт ажилласан.
- ✓ Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/226 дугаар тушаалаар “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг шалган, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллан тус газрын Контракт гэрээний эхний хагас жилийн биелэлт, замын байгууламж, хайс, тэмдэгийн бүртгэлийн судалгааг хийсэн.
- ✓ Монгол Улсын Их хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” 2018 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НӨХГ-ын даргын 2018.09.03-ны өдрийн А/465 дугаар тушаалаар хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулан 5,2 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хүлээлцсэн.
- ✓ НБГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн “Эд хогшил, тоног төхөөрөмжийн үнэлгээг магадалж, үнийн судалгаа хийх ажлын хэсэг байгуулах тухай” А/75 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан БГД-ийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт Гранд слаб ХХК-ийн барьсан 960 хүүхдийн суудалтай сургууль, 280 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгыг үзэж танилцан, БСШУСЯ-ны нийслэлд 2017 онд худалдан авсан ижил буюу адил төстэй хөрөнгийн үнийг зах зээлийн үнэтэй харьцуулан судалгааг хийсэн.

## *ЗУРГАДУГААР БҮЛЭГ.*
## *1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛУУД:*

### *6.1.1.Иргэдийн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл:*

НЗД-ын 2018 оны 02 дугаар сарын А/119 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Өргөдөл, гомдлын нэгдсэн систем Smartcity.mn-д албан хаагчдын нэвтрэх нэр болон хувийн мэдээллийг шинэчлэн оруулсан.

Смартсити цахим сайтаар нийт 61 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн хоногийг харуулбал:

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦАА




ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУГАЦАА:




2017 оны 3 дугаар улирал 2018 оны 3 дугаар улирал

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦААГ САР БҮРЭЭР ХАРЬЦУУЛБАЛ:




Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдтой уулзах 9 хүсэлт ирсний дагуу мэдээлэл, танилцуулгыг холбогдох мэргэжилтнээс авч хүргүүлсэн.

### *6.1.2.Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:*

Тайлант хугацаанд EDOC программаар ирж бүртгэгдсэн нийт 2907 албан бичгээс Захиргаа, санхүүгийн хэлтэст 613, Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэст 1557, Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэст 627, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст 110 ирж бүртгэгдсэн байна.

| № | Хэлтэс | Шийдвэрлэлт | | | Нийт | Шийдвэр лэлтийн хувь | Зөрчил | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шийдвэрл эгдсэн | Судлагдаж байгаа | Хугацаа хэтэрсэн | | | Тоо | Хувь |
| 1 | ЗСХ | 574 | 38 | 1 | 613 | 97.2% | 33 | 18.0% |
| 2 | ӨБМХ | 1463 | 94 | - | 1557 | 98.0% | 58 | 32.0% |
| 3 | ӨТМХХ | 591 | 35 | 1 | 627 | 97.2% | 84 | 46.0% |
| 4 | ХШҮХ | 106 | 4 | - | 110 | 98.1% | 8 | 4.0% |
| 5 | Нийт | 2734 | 171 | 2 | 2907 | 98.0% | 183 | 6.2% |

Нийтлэг гаргасан зөрчил: */Зарим албан бичигт давхардсан хэд хэдэн зөрчил тооцогдсон/*

1. Хугацаа хоцорч шилжүүлсэн зөрчил
2. Хяналтын зөрчил
    - Бичгийн гарчиг бичвэрийг жижиг үсгээр эхэлсэн
    - Зөв бичих дүрмийн алдаатай бичсэн
    - Бичгийн товч утгыг буруу бичсэн
    - Албан бичгийн стандарт зөрчил
    - Хавсралт материал дутуу

*Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн албан бичиг:*

| **№** | **Хэлтэс** | **Тоо / хувь** | |
|---|---|---|---|
| **1** | Захиргаа, санхүүгийн хэлтэс | 30 | 48% |
| **2** | Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс | 19 | 30% |
| **3** | Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэс | 11 | 17% |
| **4** | Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс | 3 | 5% |
| **5** | **Нийт** | **63** | |

*Ирсэн албан бичгийг графикаар үзүүлбэл:*




*Явуулсан бичгийн бүртгэл*

| № | Хэлтэс | Тоо / хувь | |
|---|---|---|---|
| 1 | Захиргаа, санхүүгийн хэлтэс | 447 | 15% |
| 2 | Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс | 1752 | 59% |
| 3 | Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэс | 654 | 22% |
| 4 | Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс | 123 | 4% |
| 5 | **Нийт** | **2976** | |

Явуулах баримт бичгийг хүлээн авч албан бичгийн стандарт, хавсралт, хаягийн бүрэн зөв эсэхийг шалган, тамга, тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүлээлгэн өгөх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд нийт 1469 ширхэг албан бичгийн дугаар өгч, 2976 албан бичгийг дугаарлан edoc программаар бүртгэн байгууллагуудад нь шилжүүлж, 400 албан бичгийг шуудангийн салбарт хүлээлгэн өгсөн.

### *6.1.3. Архивын хөтлөлтийн талаар:*

Байгууллагын 2018 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018.04.04-ний өдөр Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2018.04.10-ны өдөр баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлыг хуралдуулан байнга хадгалах хадгаламжийн нэгж 50, түр хадгалах хадгаламжийн нэгж 33, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 3 нийт 86 хадгаламжийн нэгжийг хүлээн авахаар байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулав.

Газрын даргын 2018.04.17-ны өдрийн 02 дугаартай албан даалгавраар 2017 онд үүсэн нийт 171 архивын баримтыг зохих журмын дагуу хүлээн авсан. Үүнд:

√ Байнга хадгалах 113 √ 70 жил хадгалах 3 √ Түр хадгалах 55 баримт

Албан хаагчдын архив, бичиг хэрэг хөтлөлтийг стандарт шаардлагад нийцүүлэн, албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах ажлын хүрээнд сургалт зохион байгуулсан.

Газрын даргын 2018.06.12-ны өдрийн А/251 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг нийслэлийн архивын цахим мэдээллийн санд байгууллагын 2017-2018 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийлэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, НЗД-ын захирамж, Газрын даргын байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал, хүний нөөцтэй холбоотой Б тушаалууд нийт 01-1037

хүртлэх дугаартай 2917 хуудас нийт 14 ширхэг боть архивын баримтыг /archivedoc/ программд бүртгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

| № | Баримтын төрөл | Баримтын хязгаар | Баримтын тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Байнга хадгалах хадгаламжийн нэгж | 2004- 2017 | 2895 ХН | Үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримтууд |
| 2 | Түр хадгалах хадгаламжийн нэгж | 1999-2017 | 2044 ХН | Ирсэн, явсан бичиг, харилцахын баримт |
| 3 | 70 жил хадгалах хадгаламжийн нэгж | 1991-2017 | 106 ХН | Газрын даргын “Б” тушаал, санхүүгийн баримт /нийгмийн даатгал/ |
| 4 | Тусгай төрлийн баримт | 2009-2014 | 11ХН | CD, зураг |
| | **Нийт** | 1991-2017 | 5056 ХН | Хадгаламжийн нэгж |

Архивын сан хөмрөгөөс 3 дугаар улирлын байдлаар нийт 132 баримтын лавлагаа мэдээллийг гарган, хуулбар үнэн тамга дарж баталгаажуулсан.

### *6.1.4.Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын тушаалын биелэлтийн талаар:*

Тайлант хугацаанд газрын даргын нийт 540 тушаал гарснаас “А” буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 497 тушаал, “Б” буюу хүний нөөцийн чиглэлээр 44 тушаал гаргаж 100%-ийн биелэлттэй байна.

| № | Тушаалын нэр | Тоо | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай | 223 | 100% |
| 2 | Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай | 151 | 100% |
| 3 | Ажлын хэсэг байгуулах тухай | 29 | 100% |
| 4 | Эргэлтийн бус хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай | 12 | 100% |
| 5 | Эргэлтийн бус хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай | 67 | 100% |
| 6 | Спорт өдөрлөг зохион байгуулах тухай | 1 | 100% |
| 7 | Тооллого хийх тухай | 2 | 100% |
| 8 | Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай | 2 | 100% |
| 9 | Спортын наадам цасны баярт оролцох тухай | 1 | 100% |
| 10 | Удирдлагын зөвлөлийг шинэчлэн батлах тухай | 1 | 100% |
| 11 | Зардал гаргах тухай | 8 | 100% |
| 12 | “Б” хүний нөөцийн чиглэлээр | 44 | 100% |
| | **Нийт** | **540** | **100%** |

## *6.2. Дотоод ажлын талаар:*



***Туршлага солилцох уулзалт:*** ТӨБЗГ–аас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн өмчийн газрын дарга, мэргэжилтнүүд 2018 оны 03 сарын 14-ны өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршлага судлах уулзалт хийж, цаашид хамтран ажиллах тухай санал солилцлоо.



*<u>Бүтэн өнчин хүүхдүүдийн хөгжил санг дэмжиж ажилласанд</u>* талархал илэрхийлэн тус газрын тэргүүн А.Батдорж 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга Ч.Однасанд өргөмжлөл гардууллаа.



*<u>Томуугийн вакцинд хамрагдсан:</u>* Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчид 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Томуугийн вакцинд хамрагдлаа.



*<u>“Цасны баяр” спорт арга хэмжээ:</u>* Мөнгөн Улаанбаатар спорт наадмын “Цасны баяр” арга хэмжээ 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Хандгайтын Янзага зусланд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.



*<u>Бүх нийтийн их цэвэрлэгээ:</u>* “Бүх нийтийн их цэвэрлэгээний өдөр” 2018 оны 04 дүгээр сарын 21 өдөр зохион байгуулсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний Сүхбаатарын талбайд болсон нээлтийн ажиллагаанд оролцон, хуваарийн дагуу 11:00-12:30 цагийн хооронд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших "Хөрш заан" хотхоноос Зүүн тийш "UB town " хотхон хүртэл туул голын эрэг орчмын хогийг цэвэрлэсэн.




*<u>Бүх нийтийн мод тарих өдөр:</u>* "Нийтээр мод тарих өдөр"-ийг тохиолдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын нийт албан хаагчид 2018 оны 05 дугаар сарын 12-ны 11 цагт "Монгол наадам" цогцолборт мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцсон.



*<u>Бүх нийтийн марафон уралдаан</u>* Бүх нийтээр биеийн тамир, спортыг дэмжих, эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилго бүхий “Улаанбаатар Марафон-2018” олон улсын гүйлтийн заавар журмыг албан хаагчдад танилцуулж, байгууллага, хамт олноороо идэвхтэй оролцсон.



*<u>Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр арга хэмжээ:</u>* Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Миний мөрөөдлийн

хот” гар зургийн болон эссе бичлэгийн уралдаан зарлан, шалгаруулж идэвхтэй оролцсон нийт хүүхдүүдийг шагнаж урамшуулсан. Арга хэмжээнд хүүхдүүдэд амьтан, ургамлын музей үзүүлж Эх орон, цэнгэг усаа хайрлах тухай өдөрлөг зохиосон.

## *НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьсан асуудлууд:*

- “Гудамж төсөл”-ийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын дүнд бий болсон нийт 51,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 10 байршил дахь авто зам, замын байгууламжийг ТӨБЗГ-ын 2017 оны 469 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн өмчид бүртгэх тухай тогтоолын төсөл, танилцуулгыг 2018.04.18-ны өдөр НИТХТ-ийн хуралд,
- БЗД, ЧД-ийн нутаг дэвсгэрт байрлалтай Амгалан цогцолбор сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны өргөтгөл, 62 дугаар цэцэрлэгийн барилга, ЧД-ийн ЭМТ-ийн Хайлааст салбарын амбулаторийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай тогтоолын төслийг НЗД-ын 2018.09.25-ны өдрийн 01/3739 тоот албан бичгээр НИТХ-д
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан БЗД-ийн Цагдаагийн 3 дугаар хэлтсийн 1,642,694,406 төгрөгийн өртөг бүхий барилга байгууламжийг бүртгэх асуудлыг НИТХТ-д,
- Хөгжлийн банк, нийслэлийн төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан БЗД-ийн 8, 16 дугаар хороонд байрлах 12,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий УДДТ, шугам хоолой, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай НИТХТ-ийн тогтоолын төсөл боловсруулан, хэлэлцүүлэхээр НЗД-ын 2018.09.18-ны өдрийн 01/3634 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн.

## *Цаашид авах арга хэмжээ:*

1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон, худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хяналтыг сайжруулах, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх
2. Дүүргүүдийн ОНӨҮГ-уудын эрх зүйн орчинг боловсронгуй болгож үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх
3. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах
4. “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн найруулж НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах
5. Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барьж хэлэлцүүлэх
6. “Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах бодлогын баримт бичиг” боловсруулан батлуулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
7. Нийслэлийн өмч хувьчлалын 2019 оны хөтөлбөр боловсруулж, шийдвэрлүүлэх
8. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон оролцоотой компаниудад компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх
9. Менежментийн болон удирдлагын гэрээтэй аж ахуйн нэгжүүдийн тулгамдаж буй асуудлуудыг судлан, шийдвэрлүүлэх боломжит арга хэмжээ авах
10. Нийслэлийн өмчит 21 байгууллагын 36 тээврийн хэрэгслийн чанар байдалд дүгнэлт хийсэн бөгөөд 27 тээврийн хэрэгслийг данснаас хасах асуудлыг НЗД-ын захирамжаар шийдвэрлүүлэх
11. Байгууллагын хэтийн болон өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай, дүрэм, журам, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх

12. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, шалган зааварлах ажлын хэсгийн шалгалтад бэлдэх
13. “Орон нутаг өмчтэй болсон 20 жилийн ой” арга хэмжээн хүрээнд ТӨБЗГ-аас зохион байгуулах шалгалтад бэлдэх ажлын хэсэг байгуулах
14. Байгууллагын жилийн эцсийн тайлан, мэдээг нэгтгэн, боловсруулж дээд газарт цаг тухайд нь тайлан, мэдээний нэгдсэн системээр мэдээллэх
15. Албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийг сайжруулах дээд газрын цохолттой албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх, эргэж танилцуулах асуудалд онцгой анхаарч ажиллах
16. Хариугүй албан бичгийг хүлээн авсан өдөрт нь хааж хэвшүүлэх
17. Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах
18. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудыг холбосон UBERP нэгдсэн системд байгууллагын хэмжээнд албан хаагчдын хандах эрхийг нээн, бүрэн ашигладаг болгох

| | |
|---|---|
| Тайлантай танилцсан: | Ч.Однасан /НӨХГ-ын дарга/ |
| Хянасан: | Х.Жаргалсайхан /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/ |
| Тайлан нэгтгэсэн: | Ц.Цолмон /ЗСХ-ийн мэргэжилтэн/ |
| Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн: | Ж.Сувданзаяа /ХШҮХ-ийн мэргэжилтэн/ |